

БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү төлөвлөгөө нь Нийслэлийн баянгол дүүргийн 16 хорооны нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг Монгол улсын Гамшгаас хамгаалах төрийн бодлого, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлэхэд мөрдлөг болгон баримтлах удирдлагын баримт бичиг болно.

Зорилт:

Барилгын политехник коллежийн багш, ажилчид, оюутан сурагчдын эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, Төрийн бодлогыг бүх талаар дэмжихэд оршино.

Зорилго:

Гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учрах хохирлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах явдал юм. Гол зорилгодоо хүрэхийн тулд тохиолдсон гамшгууд дээр хариу ажиллагаа явуулах төдийгүй болзошгүй гамшгийн хохирол, алдагдлыг багасгах үүднээс түүний эрсдлийг бууруулах арга хэмжээг авна. Энд гамшгийн өмнөх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг гамшгийн дараахи сэргээн босгох арга хэмжээтэй хослуулах нь зүйтэй юм.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

1. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тулгуур зарчимд үндэслэсэн Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд баримтлах залгамж чанартай үндсэн баримт бичиг мөн

1.2. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого нь гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах замаар улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэнэ.

2. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл

2.1. Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангана

2.2. Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулна

2.3. Гамшгийн нэр томъёоны ойлголт, төрийн болон хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах чиг үүрэг, тогтолцоо, гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно

2.4. Аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологийг нэвтрүүлж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсруулж, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулна

2.5. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхийг бэхжүүлнэ.

3. Тохиолдож болзошгүй гамшгийн талаар:

Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, Улаанбаатар хотын экосистемийн бүс дэх хүн амын эрчимтэй өсөлт, хэт төвлөрлийн улмаас нийслэл хотод тохиолдох аюулт үзэгдэл, ослын давтамж, учруулах хор хохирол өсч, түүний аливаа гамшигт өртөх эмзэг байдал улам бүр нэмэгдэх хандлагатай байна

Д/д	Гамшгийн ангилал		Төрөл
1	Байгалийн гамшиг	Цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл	Аянга
			Үер
		Геологийн гаралтай аюулт үзэгдэл	Газар хөдлөлт
			Хөрсний гулгалт
		Биологийн гаралтай аюулт үзэгдэл	Хортон шавьж тархах
			Хүний гоц халдварт өвчин
Мал, амьтаны гоц халдварт өвчин			
2	Хүний үйл ажиллагаатай гарч болзошгүй осол	Технологийн гаралтай	Объектийн гал түймэр
			Тоног төхөөрөмжийн осол
			Хөлдөлт
		Нийгмийн гаралтай	Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал
			Террорист халдлага

1. Газар хөдлөлтийн гамшиг:

Улаанбаатар хотыг газрын хөрсний хэв шинжээр нь авч үзвэл Туул голын сав газарт сэвсгэр хурдастай хөвсгөр хөрстэй, газар хөдлөлтийн өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрт тооцогддог бөгөөд өндөр нарийвчлалтай сансрын зураг, хээрийн ажлын судалгаагаар Улаанбаатар хот орчмын 200 км хүрээнд газар хөдлөлтөөс үүссэн хэд хэдэн шулуун ан цав тогтоогдсон нь болзошгүй газар хөдлөлтийн голомтууд болж болох магадлал бүхий бүс нутаг гэж эрдэмтэн, судлаачид тодорхойлсон. Хүчтэй газар хөдлөлт нь жилийн аль ч улиралд, өдөр шөнө ялгалгүй гэнэт тохиолдож, эгшин зуурын хугацаанд нийгэмд асар их хохирол, гамшиг учруулдаг. Газар хөдлөлтийн гамшиг нь тухайн хот суурин газрын нийгмийн амьдралын бүх хүрээнд нөлөөлж, дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, хүн амд эрүүл мэндийн болон ахуйн, бусад төрлийн тусламж,

үйлчилгээг яаралтай хүргэх, 6 дэд бүтцийн салбарт хойшлуулшгүй сэргээн босгох олон ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхийг шаарддаг.

2. Үерийн аюул:

Улаанбаатар хот орчмын гадаргын усны эх үүсвэр нь Туул, Сэлбэ, Улиастай, Толгойт, Дундгол, Баянгол зэрэг том, жижиг гол горхи, мөн хотыг хүрээлэн орших уулсын ам, олон тооны гуу жалга, сайраас ирэх бороо, цасны ус юм. Үерийн аюул үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс Цаг уурын хүчин зүйл Ус зүйн хүчин зүйл Байгалийн үерийн аюулыг даамжруулж буй хүний хүчин зүйл - Хур тунадас - Хүчтэй, салхи, шуурга - Агаарын хэм - Хөрсний чийгийн түвшин - Газрын доорх ус - Гадаргын нэвтрүүлэх байдал - Сувгийн хэлбэр - Усны хагалбарын урсацын давхцал - Ус зайлуулах барилга байгууламжийн байдал - Газар ашиглалтын зүй зохисгүй байдал /хотжилт, ой устгах нь газрын гадаргыг элэгдүүлж урсацыг нэмэгдүүлэх / - Үерийн аюултай сав газарт суурьших - Өндөрлөг газрын ус зайлуулах систем нь сайн бол нам дор газраа үерт автуулах - Уур амьсгалын өөрчлөлт хур тунадасны болон үерийн давтамж, цар хүрээг нэмэгдүүлэх - Хотын бичил уур амьсгал хур тунадасны хэмжээг нэмэгдүүлнэ. Үерийн хамгаалалтын далан, суваг эвдэрсэн, хангалтгүй, борооны ус урсдаг жалга судаг, сайр ахуйн хог, лаг шавраар дүүрсэн, зам доогуурх ус гаргах нүхэн гарц, хоолойн хөндлөн огтлол бага, зам талбайн ус зайлуулах сүлжээ хүрэлцээгүй, зарим шүүрт худаг хоолойн хэсэг битүүрсэн, хотыг хүрээлэн орших уул толгодын энгэр налуу газар болон сайр жалгыг дагаж шинээр гэр хороолол суурьшсан, автомашины төлөвлөлтгүй замаас шалтгаалж газрын хөрс хэт талхлагдаж, ургамлын бүрхэвчгүй болсон нь Улаанбаатар хот үерт автагдаж буй үндсэн шалтгаан болж байна.

3. Химийн хорт бодисын аюул:

Химийн осол нь ихэвчлэн байгалийн аюулт үзэгдэл, хүний буруутай, санамсаргүй үйл ажиллагаа болон химийн үйлдвэрлэлийн процесст доголдол гарах, тоног төхөөрөмжийн элэгдлээс шалтгаалан тохиолддог бөгөөд үүний уршгаар химийн хорт болон аюултай бодис чөлөөт болон нэгдмэл байдлаар алдагдаж хүнийг хордуулах, байгаль орчныг бохирдуулах зэрэг маш ноцтой аюулыг учруулдаг. Манай оронд 1300 гаруй аж ахуйн нэгж байгууллагад 560 орчим төрлийн 1800 гаруй тонн химийн хорт бодис хэрэглэгдэж байна. Үүний 70 гаруй хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна.

4. Объектын гал түймэр:

Гал түймэр гэдэг нь хараа хяналтгүй голомтноос үүсэн гарч, хүний эрүүл мэнд, амь насанд аюул, эд хөрөнгөд хохирол учруулдаг чөлөөт шаталт юм. Өөрөөр хэлбэл тулган дахь галыг “гал”, тулганаас гадуурх хяналтгүй галыг “гал түймэр” гэж нэрлэх нь зүйтэй. Хүн амын хэт төвлөрөл, цаг агаар, зориулалтын бус хэрэглээ зэрэг маш олон шалтгаанаар гал түймрийн аюул, гал түймрийн эрсдэл нэмэгдэж байна. Ялангуяа үйлдвэрлэл, ахуйн хэрэгцээнд шинжлэх ухаан-техникийн дэвшил ололтын үр дүнд асар хурдацтайгаар шинэ технологи, тоног төхөөрөмж, химийн бодис материал, хийц бүтээц бүхий эд зүйлс өргөн нэвтэрч тэдгээрээс учрах хор нөлөө аюул өсч байна. Гал түймрийн эрсдэл нь хүн ам, эд хөрөнгө, нийгэм, байгаль орчинд хохирол учруулах хүчин зүйлүүдийн агуулах аюулын хэмжээ, гал түймэрт өртөх эмзэг байдал, гал түймэртэй тэмцэх чадавхиар илэрхийлэгдэнэ. Гал түймрийн эмзэг байдал нь тухайн объектын онцлог, материал, хийц бүтээц, агааржуулалт, усан хангамж, автомат тоног төхөөрөмж, гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмж, объектод ажиллагсдын гал түймэр унтраах анхан шатны мэдлэг, шатлагыг дэмжих орчин, шатлага тархах нөхцөл зэргээр илэрхийлэгдэнэ. Чадавхи нь эмзэг байдалд тусгагдсан үйл ажиллагааны илэрхийлэл бөгөөд удирдлагын тогтолцоо, гал түймэртэй тэмцэх талаархи хууль эрх зүйн орчны хэрэгжилт, гал түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдал, гал түймрийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, мэдээллийн систем, сургалт

сурталчилгаа, мэдээлэл түгээх үйл ажиллагаа, нөөц, ажилтан албан хаагчдын идэвх оролцоо гэх мэтээр илэрхийлэгдэнэ.

Гамшгийн эрсдлийн үнэлгээ

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс Улаанбаатар хотын хэмжээнд гамшгийн аюул, эмзэг байдал эрсдлийн /гал түймрийн, үерийн, цацраг идэвхт, химийн хорт болон аюултай бодисын ослын, газар хөдлөлтийн, шинэ дэд хэвшлээр үүсгэгдсэн хүний томуугийн/ үнэлгээг хийсэн. Монгол Улсын хэмжээнд үйлдвэрлэлд ашиглах, худалдаалах, импортлох зөвшөөрөлтэй химийн бодисын 70 орчим хувь нь хүн ам ихээр төвлөрсөн Улаанбаатар хотод байрлаж байгаа нь Улаанбаатар хотын болзошгүй химийн ослын эрсдлийн түвшинг ихэсгэж байна. Тухайлбал: Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд хорт аюулын зэрэг өндөртэй химийн бодисыг ихээр ашиглаж, хадгалж байна. Үүнээс үүдэн химийн ослын болзошгүй эрсдэл нь Баянгол дүүрэгт $0,14 \times 10^{-4}$, харин бусад дүүргийн хувьд харьцангуй бага буюу $0,14 \times 10^{-7}$ -оос $0,45 \times 10^{-9}$ хооронд байна. Судалгаанаас Баянгол, Сонгинохайрхан дүүргүүдийн гал түймрийн эрсдлийн утга нь 10^{-4} – 10^{-3} буюу анхаарвал зохих түвшинд байгаа бөгөөд тухайн нөхцөл байдалд тохирсон урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээ авч хүлцэх эрсдлийн түвшинд хүргэх шаардлагатай байна.

Тус коллежийн барилга 1954 онд баригдсан үндсэн бүтээц нь тоосго, тоосгоны ашиглалтын хугацаа дуусаж байгаа газар хөдлөлтийн 8 баллыг тэсвэрлэж гарах магадлал 50%-тай гэж үзэж байгаа.

Барилгын политехник коллежийн дадлагын газруудад сургалтын суурин тоног төхөөрөмжүүд нь цахилгаан эрчим хүчийг ихээр ашигладаг бөгөөд объектын галын аюул ойр байдаг. Дадлагын газрууд дотороос гагнуурын дадлагын газар нь өдөр тутамдаа бүх төрлийн гагнуурын элементийг ашигладаг учир галын аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс галын хуурай хор, элс хайраг, бусад төрлийн багаж хэрэгслийг нэмэгдүүлэн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Тус коллежийн барилгын хойгуур үерийн усны далан байдаг бөгөөд уг далангийн даац хэтэрэх, эвдэрч гэмтэх тохиолдолд их хэмжээний ус объектод нэвтрэн орж ирэх эрсдэл агуулж байдаг.

Хоёр. Барилгын политехник коллежийн товч танилцуулга

Барилгын политехник коллеж нь Улаанбаатар хотын баянгол дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр, энх-тайвны өргөн чөлөө-35, баруун дөрвөн замын хойно байрлах бөгөөд 1954 онд байгуулагдсан Монгол улсын ууган барилгын төрийн өмчит сургууль. Тус сургуулийн хичээлийн програм нь 11 мэргэжлээр бүрэн дунд боловсролтой мэргэжилтэй ажилтан, 7 мэргэжлээр тусгай дунд боловсролтой техникч, 7 мэргэжлээр түр сургалтууд, 5 мэргэжлээр үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтуудыг явуулдаг. Одоогийн байдлаар 151 багш, ажилчид өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулж 2000 гаруй сурагчид хичээлийн 1, 2 дугаар байруудад суралцаа багатаамжтай. Жил болгоны хичээлийн шинэ жилээр 800 гаруй шинээр суралцагсад элсэн орлог.

Сургалтын орчин:

Нэг ээлжиндээ 540 оюутан хичээллэх хүчин чадал бүхий 4044,6 м² ашигтай талбайтай 34 хичээлийн танхим, лаборатори бүхий хичээлийн төв байр, мөн тооны оюутан хичээллэх хүчин чадалтай 2332,5 м² ашигтай талбайтай 35 хичээлийн танхим, лаборатори бүхий хичээлийн хоёрдугаар байр, 25-30 оюутан хичээллэх 227,2 м² талбай бүхий спорт сургалтын заал, 25 хүн хүлээн авах чадалтай хүндэтгэлийн өргөө, 200 хүний багатаажтай 250м² бүхий урлаг танхим, 54 м² талбай бүхий чийрэгжүүлэлтийн өрөө, 125 хүний суудалтай 35.000 ном сурах бичигтэй “VIP” номын сан уншилгын танхим, 64 м² бүхий багшийн хөгжлийн танхим, 125 хүний суудалтай цайныгазар, 1000 м² бүхий сургалтын дадлагын сэндвичин байрболон 3016 м² ашигтай талбай бүхий дөрвөн дөвхөр 300 оюутан суралцагч амьдрах хүчин чадалтай оюутны дотуур байр бүхий материаллаг баазтай.

Дадлагын газрууд:

- Барилгын сантехникийн дадлагын газар-2
- Барилгын цахилгааны дадлагын газар-2
- Цахилгаан, хийн, хагас автомат гагнуурын дадлагын газар-1
- Токарь-фрезерийн дадлагын газар-1
- Автомашины засварын дадлагын газар-1
- Барилгын засал, чимэглэлийн дадлагын газар-2
- Бетон, арматурын дадлагын газар-2
- Барилгын өрлөгийн дадлагын газар-2
- Агаар, хөргөлт, салхивчны

Лабораториуд:

- Компьютерийн лаборатори-2
- Барилгын зургийн лаборатори-1
- Физикийн лаборатори-1
- Барилгын материалын лаборатори-1
- Гидравликийн / хий шингэний үндэс / лаборатори-1
- Токарийн “CNC” машины лаборатори-1
- Цахилгааны лаборатори-1

Гамшгаас хамгаалах орон тооны бус ШТАБ мэргэжлийн анги, бүлэг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.3 дахь тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн бүтэц зохион байгуулалт гишүүдийг нэгдүгээр хавсралтаар, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэм, аюулгүй ажиллагааны зааврыг хоёрдугаар хавсралтаар, тус тус баталсугай.
2. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүтцийн дагуу ажилтан, албан хаагчдыг томилж, үүргээр ханган мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн

ажиллахыг мэргэжлийн ангийн дарга бөгөөд гамшгаас хамгаалах удирдлагын байрын дарга /О.Отгонбаатар/-т даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шаардагдах материал, техник хэрэгслээр хангуулж ажиллахыг Гамшгаас хамгаалах нөөц, хангалт хариуцсан бүлгийн ахлагч, Ерөнхий нягтлан бодогч / Н.Нарансүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ

Г.НЯМДУЛАМ

Мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн

1. Гамшгаас хамгаалах
штабын дарга
захирал/ О.Отгонбаатар /Захиргаа хариуцсан дэд
2. Штабын орлогч дарга
ажилтан/ М.Элдэв-Очир /Эрх зүй, хүний нөөцийн
3. Зарлан мэдээлэл, холбоо
хариуцсан бүлгийн ахлагч
хариуцсан Р.Мөнхжаргал /Соёл, спорт олон нийт
ажилтан/
4. Гамшгаас хамгаалах нөөц,
хангалт хариуцсан бүлгийн ахлагч
бодогч/ Н.Нарансүрэн /Ерөнхий нягтлан
5. Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан
бүлгийн ахлагч Д.Цэцэгээ /Сургуулийн эмч/
6. Сургалт, сурталчилгаа хариуцсан
бүлгийн ахлагч
менежер/ Б.Буянтогтох / Сургалт хариуцсан
7. Аюулгүй ажиллагаа хариуцсан
бүлгийн ахлагч
инженер/ Г.Дайриймаа / ХАБЭА хариуцсан
8. Сэргээн босголтын асуудал
хариуцсан бүлгийн ахлагч
менежер/ Б.Буджав / Захиргаа хариуцсан
9. Хэв журам хариуцсан
бүлгийн ахлагч
ажилтан / Ч.Живзунпагма /Нийгмийн

Гамшгаас хамгаалах томилгоот мэргэжлийн ангийн бүтэц



Дээрхи бүлгүүд бүгд галын аюулаас урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгах үүрэг хүлээн ажиллана.



ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг

Мэргэжлийн анги байгуулах нийтлэг үндэслэл

1.1. Болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг байгуулах, /цаашид “мэргэжлийн анги” гэх/ бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, шаардлагатай багаж хэрэгслээр хангах, тэдгээрийг гамшгийн голомтод ажиллуулах үеийн харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. “Мэргэжлийн анги” гэж Барилгын политехник коллежийг түшиглэсэн, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, эрэн хайх, авран хамгаалах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэхээр сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг хэлнэ.

1.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2.1-т заасныг үндэслэн захирлын шийдвэрээр мэргэжлийн ангийг байгуулна.

1.4. Төрийн байгууллага, аж ахуйн нэгж татан буугдах болон үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх тохиолдол нь тухайн мэргэжлийн ангийг татан буулгах, өөрчлөх үндэслэл болох бөгөөд энэ тухай аймаг, нийслэл, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэст мэдэгдэнэ.

Хоёрдугаар бүлэг

Мэргэжлийн ангийн гүйцэтгэх чиг үүрэг, зориулалт

2.1. Мэргэжлийн анги нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй гамшгаас хамгаалах үндсэн хүч хэрэгсэл болно.

2.2. Мэргэжлийн анги нь гамшгийн үед үүрэг гүйцэтгэх мэргэжлийн чиг үүрэг, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогтой уялдан нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, хүүхэд хамгаалал, гал түймэр унтраах, нийгмийн хэв журам сахиулах, хоол хүнсээр үйлчлэх, сэргээн босгох чиглэлээр үүрэг гүйцэтгэнэ.

2.3. Байгууллагын эрхэлж буй үйл ажиллагаа, чадавхийг харгалзан дараах тусгай зориулалтын мэргэжлийн ангийг байгуулна.

Үүнд: **Мэргэжлийн ангийн штабын даргын эрх үүрэг:** Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг удирдах, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах, тодотгох түүнийг хэрэгжүүлэх талаар гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах.

Объектыг галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар анги бүлгүүдэд заавар зөвлөмжийг хүргүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.

Байгууллагын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх Мэргэжлийн анги томилгоот бүлэгт гамшигтай тэмцэх автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах ажлыг байгууллагын төсөвт тусгаж шийдвэрлэх арга хэмжээ авах

Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа албан тушаалтан, иргэнд зааварчилгаа өгөх, хууль ёсны шаардлага тавих, түүнийг биелүүлэхийг шаардах

Мэргэжлийн ангийн штабын орлогч даргын үүрэг: Дээд газар, онцгой байдлын комиссын гаргасан шийдвэрийг өөрийн мэргэжлийн ангид хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хяналт тавих, гамшгийн цагийн байдлыг үнэлж, шийдвэр гаргахад штабын даргад дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, хөрш байгууллага, мэргэжлийн ангитай харилцан ажиллагааг зохион байгуулах.

Томилгоот бүлгүүдийг гамшгийн голомтод аврах ажиллагааг явуулахад удирдан зохион байгуулах, ажиллах нөхцөлөөр хангах.

Эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх бүлэг, гамшгийн голомтод эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, эмчлэн сувилах, халдвар эсэргүүцэх эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээг хэрэгжүүлэх. Хээрийн эмнэлэг-гамшгийн голомтод эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, олон улсын хөл хориот өвчний дэгдэлт гарсан тохиолдолд халдварт өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах. Хөдөлгөөнт эмийн сан-эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай эм, тариа, ороох, боох материалаар хангах. Эмнэлэг, эрүүл ахуй, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж, иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, бусад бүлгүүдтэй хамтран ажиллах, хүүхдийн эрхийн хамгаалалт үүсгэх, хямралт байдлын үед хүүхдэд ээлтэй орон зайг байгуулах, хүүхэд хамгааллын бусад асуудлаар үйл ажиллагаа зохион байгуулах.

Галын аюулаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий бүлгүүд нь сургууль орчим, сургуулийн дотор галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор багш, ажилтан албан хаагч, сурагчдад сургалт зохион байгуулах, мэдээллийн самбар, урьдчилан сэргийлэх багаж тогтог төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тухай бүр нь ханган ажиллана. голомтод үүссэн объектын түймрээс хүний амь нас, эд хөрөнгө, байгалийн баялагийг авран хамгаалах, гал түймрийг унтраах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг зохион байгуулан ажиллана.

Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг нь гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшүүлэх, гамшгийн аюулын тухай дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг хүргэх бүдүүвчийг боловсруулж, шалгаж байх, гамшгаас хамгаалах штаб, шуурхай бүлэг, мэргэжлийн ангийг найдвартай холбоогоор хангах, гамшгийн голомтод холбооны шугамд үүссэн гэмтлийг засварлах, сэргээх, холбоо, мэдээллийн системийн найдвартай ажиллагааг хангах, ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах, гамшгийн нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр хангах. Бүс орон нутгийн холбоо зарлан мэдээллийн албадтай харилцан ажиллагааг уялдуулан зохион байгуулна

Нөөц хангалт хариуцсан бүлэг нь Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах / гамшгийн үед хэрэглэх багаж, техник хэрэгсэл/. Гамшгийн дараах үеийн хөрөнгө санхүү, байгууллагын үнэт зүйлсийг хамгаалах, аюулгүй газарт байршуулах, иргэдийг нүүлгэн шилжүүлэх, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, нэрвэгдэгсдийг хоол, хүнсээр хангах, нөөцөөс төрөл бүрийн хангалтыг түгээх. Гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлсэн иргэдийг нэгтгэн зохион байгуулалтад

оруулж, цэвэр ус, хоол хүнс, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж үзүүлэх, аюулгүй байдлыг хангах) арга хэмжээг зохион байгуулна.

Хэв журам хариуцсан бүлэг нь Гамшгийн голомтод хэв журам сахиулах, нүүлгэн шилжүүлэх үед аюулгүй байдлыг бүх талаар хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорио цээрийн дэглэм сахиулах, объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах, нэрвэгдэгсдийг хамгаалах, хараа хяналтгүй үлдсэн сурагчид, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах. Эрэн хайх аврах ажиллагаанд оролцох хүч хэрэгслийн бэлтгэлийг ханган, гамшгийн голомтод саадгүй нэвтрүүлэх.

Сургалт сурталчилгаа хариуцсан бүлэг нь -Орон тооны бус штабын бүрэлдэхүүнд “Удирдах бүрэлдэхүүний сургалт” -Томилгоожсон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд “Мэргэжлийн ангийн сургалт” -Сурагчдад гамшгийн боловсрол олгох сургалт, хичээлийг сургалтын програмд оруулах, аливаа гамшгаас өөрийгөө хамгаалах, бусдад туслах мэдлэг дадал олгох сургалтыг сургуулийн багш, ажилчид, сурагчдад явуулна.

Тухайн орон нутгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, дээд байгууллагын тушаал шийдвэр, албан даалгавар, сэрэмжлүүлгийг сурталчилах ажлыг зохион байгуулах

Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг нь Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, объектуудын тэмдэг тэмдэглэгээ, гамшгаас хамгаалах тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, бүрдэлт зэргийг хариуцан ажиллана Гамшгийн үед цугларах байр, талбай түүнд хүрэх замын чиг чиглэл, газар зүйн солбилцол, хөдөлгөөн үйлдэх дараалал, гал түймрийн үед голомтод очих буцах зам гамшгийн хязгаарлалтын бүс зэргийг тогтооно. Гамшгаас хамгаалах штабын даргаас мэдээлэл хүлээн авч нөхцөл байдлыг нарийвчлан тогтоож бусад чиг үүрэг хариуцсан бүлгийн ахлагч, гишүүдэд гүйцэтгэх ажлын дарааллыг танилцуулж, голомтоос нэрвэгдэгсдийг татан гаргах, зөөвөрлөх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Сэргээн босголтын асуудал хариуцсан бүлэг нь Байгууллагын гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг хийлгэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гамшгийн үед тусгай чиг үүргийн томилгоот бүлгийн бүлэг ангийн даргыг хохирлын талаар мэдээллээр хангах, тогтвортой ажиллагааг хангах төлөвлөгөөг хангах.

Сэргээн босгоход шаардлагатай хүн хүч, түүхий эд, тоног төхөөрөмжийн судалгааг гаргах, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах. Гамшгийн хохирлыг шуурхай үнэлэх, дээд удирдлагад илтгэх.

Гуравдугаар бүдэг

. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дагаж мөрдөх аюулгүйн ажиллагааны заавар

Мэргэжлийн анги болон түүний дарга нь аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдож, онцгой байдал үүссэн үед гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхдээ энэхүү зааврыг дагаж мөрдөнө.

1.1. Мэргэжлийн ангийн даргын шийдвэр гаргах дараалал

1.1.1. Мэргэжлийн ангийн дарга нь Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах тухай журам”-ын дагуу бие бүрэлдэхүүнд цугларах дохио өгнө.

1.1.2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжийг хүлээж аваад гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийг заасан газарт техник, багаж хэрэгслийн хамт байрлуулна.

1.1.3. Мэргэжлийн ангийн штабын даргын шийдвэр гаргах дараалал нь гамшгийн цагийн байдал, сургуулийн даалгаврын онцлог, тухайн шатны Засаг дарга болон онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэрээс шалтгаална.

1.1.4. Мэргэжлийн ангийн дарга гамшгийн цагийн байдлын талаарх мэдээллийг хүлээн аваад тодотгох, нөхцөл байдлыг үнэлэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу харилцан ажиллагаа, хангалтыг хэрхэн зохион байгуулах шийдвэрээ бие бүрэлдэхүүнд танилцуулна.

1.2. Мэргэжлийн ангийн даргын шийдвэрт дараах нөхцөл байдлыг тусгана.

1.2.1. Мэргэжлийн ангийн цугларах байр, түүнд хүрэх замын чиглэл, газар зүйн солбилцол, хөдөлгөөн үйлдэх дараалал;

1.2.2. Гал түймэр унтраах багаж хэрэгслийн бүрдэлт, гал түймрийн голомтод очих, буцах зам, бусад хийх ажлын дарааллыг тогтоох;

1.2.3. Дайчилгаагаар хүч нэмэгдүүлэн үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүн, гамшигт нэрвэгдэгсдийг цуглуулах талбай, нэрвэгдэгсдийг зөөвөрлөх байр, гамшгийн хязгаарлалтын бүсийн тэмдэглэгээ;

1.2.4. Гал унтраах бүлгүүд эхний ээлжинд нэрвэгдэгсэдийг шатаж буй барилгаас аврах, нүүлгэн шилжүүлэх ажиллагаа явуулахад саад учруулж буй хэсэгт ажиллаж галыг унтраах;

1.2.5. Шийдвэр гаргах үед мэргэжлийн ангийн даргын байр зүйн зурагт бэлэн байх өгөгдөхүүнүүд: -өөрийн мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн боломж; - гамшигт өртсөн газар нутгийн хил хязгаарыг харуулах; -цагийн байдлыг тусгасан мэргэжлийн ангийн байр зүйн зураг; -мэргэжлийн ангийн эрэн хайх, аврах ажиллагааны бодлогыг харуулсан зураглал (цагийн байдалд тулгуурласан).

1.2.6. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед аврах ажиллагааны цагийн байдлын талаар шийдвэр гаргахдаа дараах дарааллыг баримтлана: -мэргэжлийн анги зарлан мэдээллийн дохиог хүлээн аваад хийж гүйцэтгэсэн ажил; - үүссэн цагийн байдалд үнэлэлт өгөх; - хохирлыг тооцсон байдал; -мэргэжлийн ангийн ажиллагааг эхлүүлсэн хугацаа, эрэн хайх, аврах үйл ажиллагааг хаана, хэрхэн явагдаж байгаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ; -хоногийн нөхцөл байдал, гамшгийн цар хүрээ, үүсч болох цагийн байдал;

1.2.7. Дутагдаж буй хүн хүч, техник хэрэгсэл, дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх асуудал.

1.3. Мэргэжлийн ангийн удирдлагууд нь:

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох бүхий л үе шат бүхэнд дараахь үндсэн зарчмуудыг мөрдлөг болгоно: - мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн байнгын бэлэн байдал; -гамшгаас хамгаалах үйл ажиллагааг, идэвхитэй, тогтвортой, тасралтгүй зохион байгуулах; - бусад мэргэжлийн ангиудын

хоорондын тасралтгүй харилцан ажиллагаа; - гэнэт үүссэн гамшгийн цагийн байдалд хариу арга хэмжээг авах; - хүч, хэрэгслийг шийдвэрлэх чухал хэсэг болон чиглэлд шилжүүлэн ажиллуулах; - мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн хохирлыг дайчилгаагаар ирэх нэмэлт хүч, хэрэгслээр нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах; - бие бүрэлдэхүүнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;

1.4. Аврах ажиллагаанд оролцох үеийн үйл ажиллагаа, зохицуулалт

1.4.1. Болзошгүй гамшгийн аюулаас хүн, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг аврах, сэргээн босгох ажиллагаа нь үүссэн нөхцөл байдалд тохируулан бүх талын үйл ажиллагааг иж бүрнээр тасралтгүй, шуурхай зохион байгуулахад чиглэгдсэн цогц арга хэмжээ юм.

1.4.2. Томилгоот бүлгүүд нь аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах бодит мэдээлэл цуглуулах зорилгоор гамшгийн голомтод тандалтыг явуулна.

1.4.3. Гамшгийн голомтод инженерийн техник, тоног төхөөрөмжөөр гарам, зам гарц гаргах, нүүлгэн шилжүүлэх хөдөлгөөний чиглэлийг тогтоох, ус, дулаанаар хангах, цахилгааны эвдрэл гэмтлийг засварлах, цахилгаанаар хангах арга хэмжээг зохион байгуулна.

1.4.4. Хүн ам, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгслийг голомтод хүргэх, нэрвэгдэгсдийг эмнэлэгт хүргэх, эрэн хайх, аврах, сэргээн босгох ажилд шаардлагатай бараа, бүтээгдэхүүнийг тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

1.4.5. Гамшгийн хор уршгийг арилгахад мэргэжлийн ангид шаардагдах бараа, бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

1.4.6 Хүч хэрэгслийн харилцан ажиллагааг мэргэжлийн ангийн дарга нар шуурхай зохион байгуулж, цагийн байдлын өөрчлөлттэй уялдуулан шийдвэр гаргах үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлнэ.

1.4.7 Гамшгийн голомтод мэргэжлийн ангиудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг мэргэжлийн ангийн орлогч дарга бөгөөд удирдлагын байрны дарга хүлээж, гамшгийн голомтод хүч хэрэгслийг зохион байгуулалтад оруулах, дайчлах, дэлгэх, байршуулах асуудлыг хариуцна.

2. Бие бүрэлдэхүүний дагаж мөрдөх аюулгүйн ажиллагааны заавар

2.1 Эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг явуулж байгаа мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн нь аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын төрөл бүрт мөрдөх аюулгүйн ажиллагааны зааврыг чанд сахиж, учирч болох эрсдэлээс өөрийгээ болон бусдыг хамгаалах арга дадалд суралцсан байна.

2.2 Мэргэжлийн ангийн удирдлага нь бие бүрэлдэхүүнд гамшгийн голомтын бүс, хил хязгаарыг зааж өгөх, “аюултай” гэсэн тэмдэг, тэмдэглэгээг хаана тавих, аврах, хор уршгийг арилгах ажиллагааг хэрхэн зохион байгуулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг хэрхэн сахиж ажиллах талаар зааварчилгаа өгч гарын үсэг зуруулна.

2.3 Нэрвэгдэгсдийг голомтоос гаргах зам, гарцыг автомашин, механизм ашиглан урьдчилан байгуулж, тогтоосон замаар нүүлгэнэ. Энэ үед аюултай газрыг тэмдэгжүүлж, хаалт тавина.

2.4 Аврах ажиллагаанд хэрэглэх техник, багаж хэрэгслийг ажиллуулах дадал чадварыг эзэмшээгүй хүнийг гамшгийн голомт руу нэвтрүүлэхийг хориглоно.

2.5 Цацраг, химийн хорт болон аюултай бодисоор хордсон, гал түймэрт автсан бүст аюулгүй ажиллагааны зааврыг онцгойлон анхаарах хэрэгтэй.

2.6 Аврах үйл ажиллагааны ээлж хүлээлцэхээр ирсэн мэргэжлийн ангийн бүлгийн дарга ээлжээ хүлээлгэн өгөх гэж байгаа бүлгийн даргатай тухайн голомтын гарцан дээр хүлээлцэнэ.

2.7 Хүлээлцэх үед тухайн объектод ажилласан аврах бүлгийн дарга нь ээлж хүлээлцэх үед бүлгийн даргад нөхцөл байдлыг танилцуулж, ээлж солилцох журмыг тохирч, хамтдаа нөхцөл байдлыг шинжилж үзнэ. Мөн голомтын байрлал, сүйрлийн шинж чанар, зэрэглэл, объектод явуулах эрэн хайх, аврах ажил, химийн хорт бодисын болон цацрагийн тунгийн хэмжээ, үүсч болох нөхцөл байдал, хийсэн болон хийх шаардлагатай ажлын талаар мэдээлэл солилцоно. Хүлээлцэж байгаа аврах бүлгийн дарга удирдах бүрэлдэхүүний байрлаж байгаа газар, тэдэнтэй холбоо барих журмыг мэдүүлсэн байна.

2.8 Мэргэжлийн ангийн аврах бүлгийг гамшгийн голомтоос гарсны дараа амраах, шаардлагатай бол дараагийн ажиллагаанд бэлтгэж, багаж болон хамгаалалтын хувцас, хэрэгслийг сольж, устгалд оруулах, ажилласан багаж, хэрэгсэлд техникийн үйлчилгээ хийх, ариутгах, нөхөн бүрдүүлэх арга хэмжээг авна.

2.9 Халдварт өвчний голомтод үүрэг гүйцэтгэх аврах бүлгийн хөдөлмөр хамгааллын хувцас, ажиллах багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байх бөгөөд багаж хэрэгсэл дээр ажиллах дадлагыг эзэмшсэн байна.

Газар хөдлөлтийн үед ажиллах төлөвлөгөө

А. Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Штаб болон мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг “Яаралтай цугларах” дохиогоор ажиллах чадвартай болгох. (ажлын цагт, ажлын бус цагт)	10-15 мин 45-60 мин	Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг
2	Штаб болон мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг томилгоот үүрэгт сурган дадлагажуулах	Жилд	Гамшгаас хамгаалах штабын дарга, орлогч
3	Гамшгийн зарлан мэдээллийн дохио дамжуулах хэрэгслийн байнгын бэлэн байдлыг хангах	Өдөр тутам	Зарлан мэдээлэл, холбоо

			хариуцсан бүлэг
4	Газар хөдлөлт, үүсэх цагийн байдал, тооцоо өгөгдөхүүн"-ийг жил бүр шинэчлэн тодотгож шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Жил бүр	Штабын дарга, орлогч, Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг
5	Томилгоот хүч хэрэгслийн бие бүрэлдэхүүнийг шинэчлэн тодотгон үүрэг гүйцэтгэх чадварыг байнга дээшлүүлэх, хангалтыг сайжруулах.	Жил бүр	Штабын дарга, орлогч, Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг
6	Штаб, томилгоот бүрэлдэхүүнтэй яаралтай холбоо барих хаягийг тодотгох.	Улирал тутам	Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг
7	Нийт бие бүрэлдэхүүнд холбогдох эрх зүйн дагуу сургалт явуулж мэдлэг дадлагыг дээшлүүлэх	Жил бүр	Сургалт, сурталчилгаа хариуцсан бүлэг
8	Нийт бие бүрэлдэхүүнийг гамшгийн зарлан мэдээлэл, газар хөдлөлтийн үеийн ажиллагаанд сурган дадлагажуулах	Жил бүр	Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг
9	Жил бүр шаардлагатай хөрөнгийг төсөвлөн газар хөдлөлтийн эрсдлийг бууруулах арга хэмжээ авах	Жил бүр	Нөөц, хангалт хариуцсан бүлэг

Б. Газар хөдлөлтийн үед

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Зарлан мэдээллийн техник хэрэгслээр "Гамшиг-105" өгч тэдгээрийг тогтсон цагт ажиллуулах	5-10 мин	Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг
2	Багш, ажилтан, сурагчдыг аюулгүй газарт яаралтай гаргах.	2-3 мин	Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг, Хэв журам хариуцсан бүлэг
3	Яаралтай гарах боломжгүй ажиллагсад болон гадны хүмүүс өрөө, тасалгааны хаалгыг яаралтай нээн, цонхноос зайдуу барилгын үндсэн хана, бат бөх, ширээ, тавилга ашиглан "Нуугд-Суу-Хүлээ" зарчмын дагуу газар хөдлөлтийн чичирхийлэл зогстол өөрийгөө хамгаалах арга хэмжээ авна.	2-3 мин	Хүмүүс өөрсдийгөө хамгаалах
4	Газар хөдлөлтийн дохио өгч байгаа үед аваарийн гарц хаалгуудыг яаралтай нээн, хүмүүсийг чөлөөтэй гаргах боломжоор хангах	2-4 мин	Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг Жижүүр,

В. Газар хөдлөлтийн дараа

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	“Гамшиг-105” дохиогоор ажилласан явцтай танилцан, цагийн байдлыг үнэлж аврах ажил явуулах шийдвэр гаргах	10-15 мин	Штабын дарга
2	Томилгоот хүч хэрэгсэл, сайн дурынхны хүчээр голомтонд аврах ажиллагааг явуулах	10мин-7 хоног	Штабын бие бүрэлдэхүүн
3	Нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх	5 минутаас	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг
4	Үнэт тоног төхөөрөмж, баримт бичгийг хамгаалалтанд авах	15 минутаас	Сэргээн босголтын асуудал хариуцсан бүлэг
5	Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг нөхөн хангаж тэдний хүчээр нэрвэгсдийг аврах, сэргээн босгох ажиллагаа явуулах.	1-цагаас	Штабын дарга
6	Нуранганд зам гарц гаргах, нурж болзошгүй хийцүүдийг бэхлэх буюу нураах	8-16 цагт	Штабын дарга, орлогч дарга, Сэргээн босголтын асуудал хариуцсан бүлэг
7	Нэрвэгсдийг эрж олох, эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авах	1 цагаас-3 хоног	Бүх бүлгүүд
8	Ажиллагсдын дунд халдвар эсэргүүцэх арга хэмжээг зохион байгуулах	1 цагаас эхлэн аврах ажиллагаа дуусах хүртэл	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг
9	Аврах ажиллагаанд туслалцуулахаар ирүүлсэн хүч хэрэгслийг угтан авч голомтонд оруулах	1 цагаас эхлэн аврах ажиллагаа дуусах хүртэл	Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг
10	Гамшгийн голомт бүсэд хэв журам сахиулах, хөдөлгөөн зохицуулах, материал баялгийг хамгаалах арга хэмжээ авах	15 минутаас-3 хоног	Штабын дарга, орлогч дарга.
11	Гамшгийн голомтонд байгаа иргэдийг аюулгүй газар зохион байгуулалттайгаар шилжүүлэн байршуулах, шаардлагатай материал хэрэгслээр хангах арга хэмжээ авах	30 минаас 10 цаг	Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг, Хэв журам хариуцсан бүлэг
12	Аврах, сэргээн босгох ажлын явц, дүн мэдээг дээд шатны удирдлагад танилцуулах	Өдөр бүр	Штабын дарга

Гал түймрийн үед ажиллах төлөвлөгөө

А. Гал түймрээс урьдчилан сэргийлэх

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Удирдлага болон томилгоот бие бүрэлдэхүүнийг дохиогоор ажиллах чадвартай болгох / ажлын цагт, ажлын бус цагт/	10-15 мин 45-60 мин	Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг
2	Дадлага сургууль хийж мэргэжлийн анги, багш ажилтан албан хаагч, сурагчдыг сурган дадлагажуулах	Жилд	Сургалт, сурталчилгаа хариуцсан бүлэг
3	Гамшгийн зарлан мэдээллийн дохио дамжуулах хэрэгслийн байнгын бэлэн байдлыг хангах	Өдөр тутам	Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг
4	“Гал түймэр, үүсэх цагийн байдал, тооцоо өгөгдөхүүн”-ийг жил бүр шинэчлэн тодотгож шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Жил бүр	Штабын дарга нар
5	Бие бүрэлдэхүүнүүдийн гүйцэтгэх чадварыг байнга дээшлүүлэх, хангалтыг сайжруулах	Жил бүр	Нөөц хангалт хариуцсан бүлэг
6	Хичээлийн төв байр, дадлагын газруудад үзлэг шалгалт хийж шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Жил бүр	Штабын дарга нар, Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг
7	Гал унтраах багаж техник хэрэгслийн засвар үйлчилгээ, тохируулгыг цаг тухайд нь чанартай хийх	Жил бүр	Аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг
8	Жил бүр шаардлагатай хөрөнгийг галын аюулын эрсдлийг бууруулахад захиран зарцуулах	Жил бүр	Нөөц хангалт хариуцсан бүлэг

Б. Гал түймэр гарсан үед

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Гал гарсан тухай байгууллагын удирдлага, Онцгой байдлын байгууллагын 101-д яаралтай мэдэгдэх	5-10 мин	Мэргэжлийн томилгоот бүлгүүд, жижүүр
2	“Галын дуут дохиог”-г өгч ажилтнуудыг хамгаалах арга хэмжээ авах	5-10 мин	Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг
3	Онцгой байдлын хүч хэрэгсэлтэй хамтран гал унтраах ажлыг зохион байгуулах	5-минутаас гал унтрах хүртэл	Мэргэжлийн томилгоот бүлгүүд,
4	Гал түймрийн голомтонд нэрвэгдсэн хүн амыг эрэн аварч эмнэлгийн тусламж үзүүлэх	10-20 мин	Мэргэжлийн томилгоот бүлгүүд,
5	Цахилгаан, шугам сүлжээний холбогдох хэсгийг хаах, салгах арга хэмжээ авах	5-20 мин	Мэргэжлийн томилгоот

			бүлгүүд,
6	Гал түймэр унтраах ажлын явц, дүн мэдээг дээд шатны удирдлагад танилцуулах	Тухай бүр	Штабын дарга

В. Гал түймэр унтарсаны дараа

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Гал түймэр гарсан шалтгаан нөхцлийг тодруулж, холбогдох хүмүүст хариуцлага тооцох	7 хоногт	Штабын дарга
2	Гал түймрийн хохирлыг сэргээн босгох, тогтвортой ажиллагааг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Тухай бүр	Сэргээн босголтын асуудал хариуцсан бүлэг

Хүн , малын гоц халдварт өвчний үед хэрэгжүүлэх төлөвлөгөө

А. Урьдчилан сэргийлэх талаар

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хүн малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг
2	Багш, ажиллагсад, сурагчдыг вакцинжуулалтанд бүрэн хамруулах	Жилдээ	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг
3	Орчны ариутгал, халдварын голомтонд хийх ариутгалын бодисын нөөцийг бий болгох	Жилдээ	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг
4	Сургуулийн бүсэд гарсан гоц халдварт өвчний улмаас хөдөлгөөнийг таслан зогсоож, хяналт тавих арга хэмжээг авч хэрэгжүүлэх	5-20 мин	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг

Б. Хүн, малын гоц халдварт өвчин тохиолдсон үед

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Гамшгийн талаар нийт ажиллагсад, сурагчдад зарлан мэдээлэл өгөх	5-20 мин	Зарлан мэдээлэл, холбоо хариуцсан бүлэг
2	Гамшгаас хамгаалах томилгоот бүлгүүдийг бэлэн байдалд оруулах	15-60 мин	Штабын дарга нар
3	Голомтонд хорио цээрийн дэглэм тогтоох, хэв журам сахиулах ажлыг зохион байгуулах	15-30 мин	Хэв журам хариуцсан бүлэг
4	Ариутгал халдваргүйтлийг зохион байгуулах	30-60 мин	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг
5	Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх	Гамшгийн үед	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг

В. Хүн, малын гоц халдварт өвчин тохиолдсоны дараа

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хохирлын мэдээг гаргаж, цагийн байдлын тухай холбогдох байгууллагад мэдэгдэх	60 мин	Штабын дарга
2	Өвчлөгсдийн судалгааг гаргах, сэжиг илэрсэн хүмүүстэй ойр байсан хүмүүсийг тусгаарлах.	Гамшгийн үед	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг
3	Ариутгал халдваргүйтлийг зохион байгуулах	60мин-3 хоног	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг

Гамшгийн үеийн дуудлага

1. Гал түймэр Гал-**101**
2. Хүн, мал амьтны гоц халдварт өвчин Вирус-
103
3. Үер усны аюул Давалгаа-**104**
4. Газар хөдлөлт Гамшиг-**105**
5. Цацраг химийн хордолт Бодис-**107**
6. Техникийн холбогдолтой осол -**108**
7. Террорист халдлага Аюул-**109**

БАТЛАВ: БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА, ОНЦГОЙ БАЙДЛЫН
ХУРАНДАА.....А.БАТМӨНХ

БАТЛАВ: БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
.....Г.НЯМДУЛАМ

ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Боловсруулсан: Эрх зүй, хүний нөөц хариуцсан ажилтан М.Элдэв-Очир

2018 оны 03 дугаар сарын 20

Тодотгосон.....он....сар....өдөр

.....он....сар....өдөр

Хянасан: Баянгол дүүргийн онцгой байдлын хэлтэсийн

Мэргэжилтэн.....Ц.Гантулга